

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.... оныдугаар
сарын.....-ны өдөр

Улаанбаатар хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гаалийн тариф, тарифын хөнгөлөлт, барааны үнэ, ангилал, гарал үүслийг тодорхойлох, гаалийн болон бусад татвар ногдуулах, хураах, төлөх, нөхөн төлүүлэх, хойшлуулах, буцаан олгох, баталгаа гаргах, гаалийн татвараас чөлөөлөх, урьдчилсан шийдвэр гаргах, худалдааны хамгаалалтын хариу арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль тогтоомж

2.1.Монгол Улсын гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Татварын ерөнхий хууль, Гаалийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“гаалийн тариф” гэж гаалийн татварын хувь, хэмжээг;

3.1.2.“гаалийн татвар” гэж гаалийн нутаг дэвсгэрт оруулах, эсхүл түүнээс гаргах бараанд гаалийн тарифын дагуу ногдуулах, хураах, төлөх албан татварыг;

3.1.3.“бусад татвар” гэж гаалийн нутаг дэвсгэрт оруулах, эсхүл түүнээс гаргах бараанд бусад хуулийн дагуу ногдуулах, хураах, төлөх албан татварыг;

3.1.4.“гаалийн үнэ” гэж гаалийн татвар ногдуулах, гаалийн статистикийн мэдээлэл гаргах зорилгоор энэ хуулийн дагуу тодорхойлох үнийг;

3.1.5. “барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем” /цаашид “Уялдуулсан систем” гэх/ гэж Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай олон улсын конвенцид хавсаргасан, зүйл болон мөр, мөн тэдгээрийн тоон код, хэсэг, бүлэг, мөрийн тайлбар бүхий жагсаалт, болон Уялдуулсан системийн тайлбар дүрмийг;

3.1.6. “гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт” гэж Уялдуулсан системд үндэслэсэн, зүйл, мөр, үндэсний код, тэдгээрт харгалзах барааны бичиглэл, хэмжих нэгж мөн хэсэг, бүлэг, мөр, үндэсний кодын тайлбар, бүхий жагсаалт, уялдуулсан системийн тайлбар дүрмийг;

3.1.7. “татвар төлөгч” гэж гаалийн хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүрэг бүхий этгээдийг;

3.1.8. “ойролцоо хугацаа” гэж үнэлж буй импортын барааны гаалийн үнийг гаалийн байгууллагад мэдүүлсэн өдрөөс өмнөх 90 хоногийг;

3.1.9. “гаалийн болон бусад татвар ногдуулах” гэж энэ хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу албан татвар тооцохыг;

3.1.10. “гаалийн болон бусад татвар хураах” гэж энэ хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу ногдуулсан албан татварыг гаалийн байгууллага улсын төсөвт төвлөрүүлэхийг;

3.1.11. “гаалийн болон бусад татвар төлөх” гэж энэ хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу ногдуулсан албан татварыг татвар төлөгч холбогдох татварын дансанд шилжүүлэхийг;

3.1.12. “хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн бараа” гэж Монгол Улсын Засгийн газраас гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай байгуулсан гэрээний дагуу хариу төлбөргүйгээр хүлээн авсан барааг;

3.1.13. “татвараас чөлөөлөх” гэж ашиглалт, захиран зарцуулалтын хязгаарлалттайгаар импортын гаалийн татвараас чөлөөлөхийг;

3.1.14. “гаалийн тарифын хөнгөлөлт” гэж:

3.1.14.1. эрх бүхий байгууллагаас гаалийн тарифыг бууруулах, тэглэхийг;

3.1.14.2. Монгол улсын олон улсын гэрээгээр харилцан тохиролцсоны дагуу гаалийн тарифыг бууруулах, тэглэхийг;

3.1.15. “худалдааны хамгаалалтын хариу арга хэрэгсэл (trade remedies)” гэж дотоодын зах зээл болон үйлдвэрлэлийг хамгаалах, шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор гаалийн нутаг дэвсгэрт оруулах бараанд авах хамгаалалтын (safeguard), демпингийн эсрэг (antidumping), эсхүл хариу арга хэмжээг (countervailing);

3.1.16. “урьдчилсан шийдвэр” гэж хүсэлт гаргагч этгээдийн хүсэлтээр барааг улсын хилээр оруулах, өмнө тухайн барааны ангилал, гарал үүслийг тодорхойлж гаалийн байгууллагаас гаргасан шийдвэрийг.

3.2. Энэ хуульд хэрэглэсэн гаалийн үйл ажиллагаатай холбоотой бусад нэр томъёог Гаалийн тухай хуульд тайлбарласан утгаар ойлгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ГААЛИЙН ТАРИФЫН ТОГТОЛЦОО, ГААЛИЙН ТАТВАР ТОГТООХ ХЭЛБЭР, ГААЛИЙН ТАРИФЫН ЗӨВЛӨЛ

4 дүгээр зүйл. Гаалийн тарифын тогтолцоо, төрөл, тарифыг тогтоох, өөрчлөх

4.1 Монгол Улсад экспортын болон импортын барааны гаалийн тарифыг хэрэглэх бөгөөд гаалийн тарифыг тогтоохдоо барааны ангиллын код, нэр төрлийг гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтын дагуу заана.

4.2. Импортын барааны гаалийн тариф нь ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй тариф гэсэн төрөлтэй байх бөгөөд ердийн тариф нэн тааламжтай тарифаас хоёр дахин их байна. Хөнгөлөлттэй тарифыг олон улсын гэрээгээр тогтооно.

4.3. Экспортын барааны гаалийн тариф болон импортын барааны нэн тааламжтай тарифыг Улсын Их Хурал тогтооно.

4.4. Дор дурдсан гадаад улсаас гарал үүсэлтэй бараанд нэн тааламжтай тариф хэрэглэнэ:

4.4.1. Монгол Улсын нэгдэн орсон тариф, худалдааны талаарх олон талт гэрээний гишүүн улс;

4.4.2. энэ хуулийн 4.4.1-д зааснаас бусад олон улсын гэрээний дагуу тохиролцсон улс;

4.4.3. нэн тааламжтай тариф хэрэглэх нь зүйтэй гэж үзсэн бусад улс.

4.5. Нэн тааламжтай болон хөнгөлөлттэй тариф хэрэглэх улсын жагсаалтыг Засгийн газар батлах бөгөөд уг жагсаалтад хамаарах улсын гарал үүсэлтэй бараа нь гарал үүслийг нотлох бичиг баримттай байна.

4.6. Энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад ороогүй улсын гарал үүсэлтэй бараанд, эсхүл гарал үүслийг нотлох бичиг баримтгүй бараанд ердийн тариф хэрэглэнэ.

4.7. Энэ хуулийн 4.5-д заасан барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулахыг гаалийн байгууллага зөвшөөрсөн өдрөөс хойш уг барааны гарал үүслийг нотлох баримт бичгийг 30 хоногийн дотор нөхөн гаргаж өгсөн бол нэн тааламжтай, эсхүл хөнгөлөлттэй тариф хэрэглэж болох бөгөөд энэ тохиолдолд илүү төлсөн татварыг гаалийн байгууллага буцаан олгоно.

Тайлбар: Гаалийн хяналт, шалгалтын үр дүнд барааны тоо хэмжээ, нэр төрлийг худал мэдүүлсэн болох нь тогтоогдсон бол уг барааны мэдүүлээгүй тоо хэмжээнд энэ заалт хамаарахгүй.

4.8. Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу импортын бараанд гаалийн хөнгөлөлттэй тариф хэрэглэнэ.

4.9. Хөнгөлөлттэй тариф хэрэглэх улсаас ирсэн бөгөөд гарал үүслийн гэрчилгээгүй бараанд энэ хуулийн 29.4.1, эсхүл 29.4.2-д заасан нотлох бичиг баримтыг үндэслэн нэн тааламжтай тариф хэрэглэнэ.

4.10. Гаалийн тарифыг түр хугацаагаар тогтоож болох бөгөөд ийнхүү түр хугацаагаар тогтоосон тарифыг мөрдөх хугацаа жилд 6 сараас хэтрэхээргүй байна.

4.11.Г аалийн тарифыг хилийн боомтоор тогтоож болно.

4.12.Олон улсын гэрээ болон үндэсний хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол гаалийн тарифт оруулсан өөрчлөлтийг төсвийн жилийн эхний өдрөөс эхлэн мөрдөнө.

5 дугаар зүйл. Гаалийн татвар тогтоох хэлбэр

5.1. Гаалийн татварыг дараах хэлбэрээр тогтооно:

5.1.1.гаалийн үнээс хувиар;

5.1.2 барааны тоо, жин, хэмжээ, эзлэхүүн, эсхүл бусад биет хэмжигдэхүүний нэгжид мөнгөн илэрхийллээр;

5.1.3.энэ хуулийн 5.1.1, 5.1.2-т заасан хэлбэрийг дангаар, эсхүл хослуулан;

5.1.4.энэ хуулийн 5.1.1, 5.1.2-т заасан хэлбэрээс гаалийн өндөр татвартайг нь сонгоно.

6 дугаар зүйл. Худалдааны хамгаалалтын хариу арга хэрэгсэл

6.1. Худалдааны хамгаалалтын хариу арга хэрэгсэл ашиглах тохиолдолд импортын барааны гаалийн нэн тааламжтай тарифыг Засгийн газар дараах байдлаар нэмэгдүүлэн тогтоож болно:

6.1.1. түр хугацаагаар;

6.1.2. тухайн хариу арга хэмжээ үргэлжлэх хугацаагаар.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан нэмэгдүүлсэн нэн тааламжтай тарифыг тухайн арга хэмжээнд хамрагдсан улс, гадаадын этгээдийн бараанд ногдуулна.

6.3. Энэ зүйлд заасан худалдааны хамгаалалтын хариу арга хэмжээний харилцааг зохицуулсан журмыг Монгол Улсын Засгийн газар батална.

7 дугаар зүйл. Гаалийн тарифын зөвлөл

7.1. Гаалийн татвар, тарифын зохистой тогтолцоог бүрдүүлэх, гаалийн татварын хувь, хэмжээг оновчтой тогтоох асуудлаар дүгнэлт гаргах, санал боловсруулах үүрэг бүхий гаалийн тарифын орон тооны бус зөвлөл ажиллах ба бүрэлдэхүүн, дүрмийг нь Засгийн газар батална.

7.2. Энэ хуулийн 7.1-д заасан зөвлөлийн дарга нь Монгол Улсын Засгийн газрын гишүүн байх бөгөөд түүнийг Засгийн газраас томилж, чөлөөлөх ба нарийн бичгийн дарга нь орон тооных байна.

7.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнд гааль, татвар, төсөв, санхүү, гадаад худалдааны болон салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын төлөөллөөс гадна эрдэм шинжилгээ, судалгааны болон ашгийн ба ашгийн бус хуулийн этгээдийн төлөөллийг оролцуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ГААЛИЙН ҮНИЙГ МЭДҮҮЛЭХ, ШАЛГАХ

8 дугаар зүйл. Гаалийн үнийг тодорхойлж мэдүүлэх

8.1. Мэдүүлэгч нь гаалийн бүрдүүлэлтийн тухайн горимд шаардагдах бичиг баримтыг үндэслэн гаалийн үнийг тодорхойлж, гаалийн байгууллагад мэдүүлэх ба ингэхдээ дурын, эсхүл зохиомол үнэ хэрэглэхийг хориглоно.

8.2. Мэдүүлэгч нь өөрийнхөө сонгосон гаалийн үнийг тодорхойлох арга болон гаалийн үнийг тодорхойлсон бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгөх үүрэгтэй.

8.3. Энэ хуулийн 8.2-т заасан бичиг баримт нь бодитой мэдээлэл дээр үндэслэгдсэн, тоон үзүүлэлтээр илэрхийлэгдсэн байвал зохино.

9 дүгээр зүйл. Гаалийн үнийг шалгах

9.1. Гаалийн үнийг тодорхойлох арга болон гаалийн үнийг мэдүүлэгч үнэн зөв, бодитой тодорхойлсон эсэхийг гаалийн байгууллага шалгаж, шийдвэр гаргана.

9.2. Мэдүүлэгчийн гаргаж өгсөн бичиг баримт нь гаалийн үнийг шалгаж, шийдвэр гаргахад хангалтгүй гэж үзвэл гаалийн байгууллага мэдүүлэгчтэй зөвлөлдөн нэмэлт мэдээлэл, бичиг баримт гаргуулан авч болно.

9.3. Гаалийн байгууллага нь дараах тохиолдолд бодит мэдээллийг үндэслэн гаалийн үнийг мэдүүлэгчийн тодорхойлсноос өөр аргаар тодорхойлж болно:

9.3.1. гаалийн үнийг тодорхойлоход ашигласан бичиг баримт баталгаажаагүй, эсхүл түүнд тусгагдсан мэдээлэл зөрсөн, бүрэн бус, тоон үзүүлэлт нь хангалтгүй байсан бол;

9.3.2. мэдүүлэгч гаалийн үнийн үнэн зөвийг нотолж чадаагүй бөгөөд гаалийн байгууллага мэдүүлэгчийн тодорхойлсон үнийг үндэслэлгүй гэж үзсэн бол.

9.4. Энэ хуулийн 9.3-т заасан тохиолдолд гаалийн байгууллагын өөр аргаар тодорхойлсон үнээс гаалийн болон бусад татварыг ногдуулж, мэдүүлэгчээр төлүүлнэ.

9.5. Гаалийн байгууллага энэ хуулийн 9.3-т заасны дагуу гаалийн үнийг тодорхойлсон тохиолдолд мэдүүлэгч гаалийн байгууллагад бичгээр хүсэлт тавьж, бичгээр тайлбар гаргуулан авч болно.

9.6. Мэдүүлэгч энэ хуулийн 9.3-т заасны дагуу гаалийн байгууллагаас тодорхойлсон гаалийн үнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол уг үнийг тодорхойлсноос

хойш 30 хоногийн дотор нэмэлт нотлох баримт гарган өөрийн мэдүүлсэн үнийг үнэн зөв гэдгийг нотолсон тохиолдолд гаалийн байгууллага мэдүүлэгчийн тодорхойлсон үнийг үндэслэн гаалийн болон бусад татвар ногдуулж болно.

9.7. Гаалийн байгууллага энэ хуулийн 9.6-д заасан мэдүүлэгчээс гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзвал мэдүүлэгч нь Гаалийн тухай хуульд заасны дагуу гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.

9.8. Гомдлыг хянан шийдвэрлэх явцад энэ хуулийн 39.2-д заасны дагуу баталгаа гаргуулан мэдүүлэгчид барааг олгож болно.

9.9. Гаалийн үнийг магадлан шалгах явцад гарсан зардлыг мэдүүлэгч хариуцна.

9.10. Гаалийн бүрдүүлэлтийн горим өөрчлөгдөхөд мэдүүлэгчийн сонгосон анхны горимд байршуулсан мэдүүлгийн барааны гаалийн үнэ дор зааснаас бусад тохиолдолд хэвээр байна:

9.10.1. ре-экспорт, ре-импортын барааг өөр этгээдтэй байгуулсан гэрээгээр оруулахад, эсхүл гаргахад;

9.10.2. бараа гаалийн баталгаат агуулах, чөлөөт бүсэд байх хугацаанд гадаад худалдааны өөр гэрээ байгуулах;

9.10.3. татвараас чөлөөлөгдсөн тээврийн хэрэгсэл, машин механизм, техник тоног төхөөрөмжийн элэгдэл хорогдлыг тооцох.

9.11. Хүчин төгөлдөр болсон мэдүүлгийн гаалийн үнэд дараах тохиолдолд өөрчлөлт оруулж болно:

9.11.1. гаалийн байгууллагын дотоод хяналт болон бусад шалгалтаар гаалийн үнийг буруу мэдүүлсэн нь тогтоогдсон;

9.11.2. энэ хуулийн 9.6, 9.7-д заасны дагуу гаалийн байгууллагын тодорхойлсон үнээс татгалзсан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН ҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ

10 дугаар зүйл. Гаалийн үнийг тодорхойлох арга

10.1. Импортын барааны гаалийн үнийг тодорхойлоход дараах аргуудыг дор дурдсан дарааллын дагуу хэрэглэнэ:

10.1.1. хэлцлийн үнийн арга;

10.1.2. нэг төрлийн барааны хэлцлийн үнийн арга;

10.1.3. ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга;

10.1.4. ялгаварт үнийн арга;

10.1.5. нийлбэр үнийн арга;

10.1.6. уялдуулан хэрэглэх үнийн арга.

10.2. Мэдүүлэгчийн хүсэлтээр энэ хуулийн 10.1.4, 10.1.5-д заасан аргын дарааллыг сольж хэрэглэж болно.

10.3. Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан аргуудаар гаалийн үнийг тодорхойлохдоо дэс дарааллыг мөрдөнө.

11 дүгээр зүйл. Хэлцлийн үнийн арга

11.1. Хэлцлийн үнийн аргыг импортын барааны гаалийн үнийг тодорхойлох үндсэн арга гэж үзнэ.

11.2. Хилийн чанадаас Монгол Улсад экспортоор худалдсан барааны худалдан авагчаас худалдагчид шууд болон шууд бус байдлаар төлсөн, эсхүл төлбөл зохих бодит үнийг импортын барааны хэлцлийн үнэ гэнэ.

11.3. Энэ хуулийн 11.1-д заасан аргаар гаалийн үнийг тодорхойлохдоо хэлцлийн үнэд ороогүй, эсхүл хэлцлийн үнээс тусдаа ялгарч харагдах тоон үзүүлэлтээр илэрхийлэгдсэн бөгөөд гадаад худалдаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үндэслэлтэй мэдээ баримтад тулгуурласан дараах зардлыг нэмж тооцно:

11.3.1. тухайн барааг Монгол Улсын хилийн өртөө хүртэл тээвэрлэхтэй холбогдон гарсан дараах зардал:

11.3.1.1. тээврийн зардал, тээврийн болон экспортын бичиг баримт бүрдүүлэхэд гарсан зардал, тээврийн хэрэгсэл болон чингэлэг ашиглалтын хөлс, түрээсийн төлбөр;

11.3.1.2. тээвэрлэлтийн явцад барааг арчлан хамгаалахад гарсан зардал, тухайлбал, шаардлагатай дулаан, чийг, агааржуулалт, хөргөлтөд гарах зардал, түүнчлэн хэрвээ амьд амьтан бол түүнийг хооллох, эмчлэх, маллах зэрэг тухайн барааны бүрэн бүтэн байдал, чанарыг хадгалахтай холбогдон гарах зардал;

11.3.1.3. даатгалын хураамж.

11.3.1.4. хэрэв барааг үнэгүй тээвэрлэсэн, эсвэл худалдан авагч өөрийн тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн бол адил төстэй тээврийн хэрэгслийн тухайн үед мөрдөгдөж байгаа тарифтай дүйцэх зардал;

11.3.1.5. авто тээврийн хэрэгслээр барааг тээвэрлэх үед дээрх баримт мэдээлэл байхгүй тохиолдолд тухайн тээвэрлэлтийг зохион байгуулж байгаа аж ахуйн нэгжийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримтад тулгуурлан тооцсон зардал, эсхүл тухайн тээврийн хэрэгслийн зарцуулсан шатахууны үнэ болон жолоочийн хөлс, тээврийн хэрэгслийн элэгдлийг тооцсон зардал.

11.3.2. худалдан авагч хариуцан гүйцэтгэсэн боловч тухайн бараанд төлсөн буюу төлбөл зохих дараах зардал:

11.3.2.1. худалдан авахаас бусад комиссын шимтгэл болон зуучлагчийн хөлс;

11.3.2.2. гаалийн зорилгоор тухайн бараатай нэгдмэл байдлаар тооцогдох сав, баглаа боодлын зардал;

11.3.3. тухайн барааг үйлдвэрлэх, Монгол Улсад экспортлохтой холбогдуулан ашиглуулахаар худалдан авагчаас худалдагчид, эсхүл үйлдвэрлэгчид шууд болон шууд бус хэлбэрээр үнэ төлбөргүй, эсхүл хямдруулсан үнээр нийлүүлсэн дараах бараа, ажил, үйлчилгээний өртгийн зохих хэсэг:

- 11.3.3.1. үнэлж байгаа импортын бараанд бүрэлдэхүүн хэсэг болгон нэгтгэсэн материал, бүрдэл хэсэг, эд анги болон тэдгээртэй төстэй зүйлс;
- 11.3.3.2. тухайн импортын барааг үйлдвэрлэх үед ашигласан багаж хэрэгсэл, хэв, загвар болон тэдгээртэй төстэй зүйлс;
- 11.3.3.3. тухайн импортын барааг үйлдвэрлэх явцад зарцуулсан материал (тосолгооны материал, шатахуун, түлш гэх мэт зүйлс);
- 11.3.3.4. тухайн импортын барааг үйлдвэрлэхэд шаардлагатай бөгөөд Монгол Улсаас өөр улс оронд хийж гүйцэтгэсэн инженерийн болон өөрчлөн шинэчлэх шийдэл, урлал чимэглэлийн болон дизайны ажил, ерөнхий бүдүүвч болон техникийн зураг төсөл.

Тайлбар: "Өртгийн зохих хэсэг" гэдэгт тухайн бараанд бодитой зарцуулагдсан буюу үйлдвэрлэлийн явцад технологийн ажиллагаанаас хамааран зайлшгүй гарах материалын хаягдал, хэвийн хорогдлыг хасч тооцсон өртгийг ойлгоно.

11.3.4. тухайн барааг худалдан борлуулах нөхцөл болгон худалдан авагчаас худалдагчид шууд болон шууд бус хэлбэрээр төлсөн, эсхүл төлөх оюуны өмч ашигласны төлбөр;

11.3.5. худалдан авагч тухайн барааг худалдан борлуулсан, захиран зарцуулсан, ашигласнаас олох орлогоосоо шууд болон шууд бус хэлбэрээр худалдагчид төлөх хэсэг.

11.4. Энэ хуулийн 11.1-д заасан аргаар гаалийн үнийг тодорхойлохдоо хэлцлийн үнэд орсон бөгөөд тусдаа ялгарч харагдах тоон үзүүлэлтээр илэрхийлэгдсэн, гадаад худалдаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үндэслэлтэй мэдээ баримтад тулгуурласан дараах зардлыг хасч тооцно:

- 11.4.1. үйлдвэрлэлийн хэрэгсэл, машин, тоног төхөөрөмж зэрэг барааг импортолсны дараа суурилуулах, угсрах, засварлах болон техникийн тусалцаа үзүүлэх, сургалт явуулах зардал;
- 11.4.2. гаалийн хилээр оруулсны дараах тээврийн зардал;
- 11.4.3. импортлогч орны гаалийн болон бусад татвар.

11.5. Нэг ачилтаар хэд хэдэн нэр төрлийн барааг улсын хилээр оруулж ирсэн тохиолдолд хэлцлийн үнэ дээр нэмэгдэх, эсхүл хэлцлийн үнээс хасвал зохих тээврийн зардлыг бараа болгонд хуваарилахдаа нийт ачилтын цэвэр жинд тухайн барааны ногдох жинг харьцуулна, харин даатгалын зардлыг барааны үнийн дүнг харгалзан хуваарилах ба ийнхүү жин болон үнийн дүнг харьцуулан зардлыг хуваарилах боломжгүй бол эзлэхүүнийг харгалзан зардлыг хуваарилж болно.

11.6. Худалдан авагчийн тухайн барааг худалдах, хэрэглэх буюу ашиглах эрхийг Монгол Улсын хууль тогтоомжоор хязгаарласан, эсхүл худалдан борлуулах бүс нутгийг заагласан, түүнчлэн барааны үнэд үл нөлөөлөх бусад хязгаарлалт тогтоосон нь хэлцлийн үнийн аргыг хэрэглэхэд саад болохгүй.

11.7. Дараах тохиолдолд хэлцлийн үнийн аргыг хэрэглэхийг хориглоно:

11.7.1. худалдан авагчийн захиран зарцуулах, эсхүл ашиглах эрхийг энэ хуулийн 11.6-д зааснаас өөр үндэслэлээр хязгаарласан;

11.7.2.барааг худалдах, хэрэглэх буюу ашиглах, эсхүл устгахтай холбоотой худалдан авагчийн эрхийг хязгаарласан хэлцэл ба үнэ нь энэ хуулийн 11.2-т заасан хэлцлийн үнийн нөхцөл, шаардлагаас өөрөөр тодорхойлогдсон;

11.7.3.барааг худалдах, хэрэглэх буюу ашиглах, эсхүл устгахтай холбоотой худалдан авагчийн эрхийг хязгаарласан хэлцэл ба үнэ нь энэ хуулийн 11.2-т заасан хэлцлийн үнийн нөхцөл, шаардлагаас өөрөөр тодорхойлогдсон;

11.7.4.импортын барааг худалдсан, хэрэглэсэн буюу ашигласнаас орох орлогоос худалдагчид ногдох хэсгийг тодорхойлох боломжгүй бол;

11.7.5.худалдах, худалдан авах ажиллагаа нь энэ хуулийн 11.8-д заасан харилцан хамааралтай этгээдийн хооронд хийгдсэн бөгөөд хэлцлийн үнэ нь мөн хуулийн 11.9-д заасан шалгуур үнэтэй ойролцоо биш бол.

11.8. Дараах тохиолдолд худалдагч, худалдан авагчийг харилцан хамаарал бүхий этгээд гэж үзнэ:

11.8.1.бие биеийнхээ бизнесийн (компанийн) захирал, эсхүл ажилтан бол;

11.8.2.хууль эрх зүйн хүрээнд зөвшөөрөгдсөн бизнесийн хамтрагчид бол;

11.8.3.нэг нь ажил олгогч, нөгөө нь ажилтан бол;

11.8.4.бие биеийнхээ саналын эрхтэй хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг шууд буюу шууд бус хэлбэрээр эзэмшдэг бол;

11.8.5.нэг нь нөгөөдөө шууд буюу шууд бус хэлбэрээр хяналт тавьдаг бол;

11.8.6.худалдагч, худалдан авагч аль аль нь гуравдагч нэг этгээдийн шууд буюу шууд бус хяналтад байгаа бол;

11.8.7.худалдагч, худалдан авагч аль аль нь гуравдагч нэг этгээдийг шууд буюу шууд бус байдлаар хянадаг бол;

11.8.8.нэг гэр бүлийн гишүүн, эсхүл төрөл, садангийн хүмүүс бол.

11.9. Энэ хуулийн 11.8-д заасан харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн худалдааны хэлцлийн үнэ нь импортолсон барааны шинж байдал, үйлдвэрлэлийн онцлог, гаалийн хилээр нэвтрүүлж байгаа улирал, үнийн зөрүү зэрэг үзүүлэлтээр дараах шалгуур үнэтэй ойролцоо хэмжээнд тодорхойлогдсон байвал хэлцлийн үнийн аргыг хэрэглэнэ:

11.9.1.энэ хуулийн 11.8-д заасан этгээдийн импортолсон нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны худалдааны хэлцлийн үнэ нь харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдсэн худалдааны хэлцлийн үнэтэй ойролцоо бол;

11.9.2.энэ хуулийн 11.8-д заасан этгээдийн импортолсон нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны худалдааны хэлцлийн үнэ нь урьд нь гаалийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн гаалийн үнэтэй ойролцоо бол.

11.10.Энэ хуулийн 11.9-д дурдсан шалгуур үнэтэй харьцуулалт хийхдээ худалдааны түвшин, барааны тоо хэмжээ, энэ хуулийн 11.3, 11.4-т заасан зардлыг тооцно.

12 дугаар зүйл. Нэг төрлийн барааны хэлцлийн үнийн арга

12.1.Импортолж буй барааны гаалийн үнийг хэлцлийн үнийн аргаар тодорхойлох боломжгүй бол гаалийн үнийг нь тодорхойлж буй бараатай нэгэн зэрэг, эсхүл энэ хуулийн 3.1.8-д заасан хугацаанд импортолсон нэг төрлийн барааны хэлцлийн үнээр тодорхойлно.

12.2.“Нэг төрлийн бараа” гэдэгт үнийг нь тодорхойлж байгаа бараатай дараах шинж тэмдгээр адил барааг ойлгоно:

12.2.1. бодит шинж буюу хэмжээ хэлбэр, бэлтгэсэн болон үйлдвэрлэсэн арга, физикийн, химийн шинж чанар, техникийн үзүүлэлт;

12.2.2.чанар, барааны тэмдэг болон барааны нэр хүнд;

12.2.3.барааны гарал үүслийн улс;

12.2.4.үйлдвэрлэгч.

12.3.Нэг төрлийн барааны хэлцлийн үнийн аргаар гаалийн үнийг тодорхойлоход худалдааны адил түвшинд, ойролцоо тоо хэмжээгээр импортлосон нэг төрлийн барааны хэлцлийн үнийг үндэслэнэ.

12.4.Хэрэв нэг төрлийн бараа нь энэ хуулийн 12.3-т зааснаас өөр тоо хэмжээтэй, эсхүл худалдааны өөр түвшинд импортлогдсон байвал мэдүүлэгч зөрүүг харгалзан үнийн зохих өөрчлөлт хийж, үндэслэлийг баримтаар нотолно.

12.5. Нэг төрлийн бараа гаалийн үнийг нь тодорхойлж байгаа бараанаас гадаад харагдахуйц байдал (хэмжээ, өнгө гэх мэт)-аараа ялимгүй ялгаатай байх нь нэг төрлийн барааны хэлцлийн үнийн аргыг хэрэглэхээс татгалзах үндэслэл болохгүй.

12.6.Нэг төрлийн барааны хэлцлийн үнэ нь гаалийн байгууллагад хүлээн зөвшөөрөгдсөн үнэ байх бөгөөд уг үнэд барааг тээвэрлэх зай, ашиглах тээврийн хэрэгслийн төрлөөс хамаарах залруулга, тодотгол хийж болох бөгөөд эдгээр залруулга, тодотгол нь үндэслэлтэй, үнэн зөв болохыг нотлох бичиг баримтаар баталгаажуулна.

12.7.Энэ хуулийн 12.6-д заасан хүлээн зөвшөөрөгдсөн үнэд залруулга, тодотгол хийх шаардлагатай боловч тэдгээрийг хийх боломжгүй, эсхүл залруулга, тодотголыг баталгаажуулах бичиг баримтгүй бол нэг төрлийн барааны хэлцлийн үнийн аргыг хэрэглэхийг хориглоно.

12.8.Нэг төрлийн барааны хэлцлийн үнийн аргаар гаалийн үнийг тодорхойлоход энэ хуулийн 11.3-т заасан зардлыг тооцно.

12.9.Нэг төрлийн барааны хэд хэдэн хэлцлийн үнийг үндэслэн гаалийн үнийг тодорхойлж болохоор байвал хамгийн бага үнийг нь сонгож хэрэглэнэ.

12.10.Нэг төрлийн барааны хэлцлийн үнийн аргаар гаалийн үнийг тодорхойлоход дараах барааны үнийг хэрэглэхийг хориглоно:

12.10.1.дотоодын хэрэглээнд зориулан оруулахаас бусад горимд байршуулсан бараа;

12.10.2.Засгийн газрын болон Засгийн газрын бус зээлийн шугамаар оруулсан бараа;

12.10.3.Засгийн газрын болон Засгийн газрын бус өр төлбөрийн шугамаар оруулсан бараа;

12.10.4.хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн бараа;

12.10.5.түрээсийн бараа;

12.10.6.гадаадын хөрөнгө оруулалтаар оруулсан бараа;

12.10.7.их засварын тоног төхөөрөмж;

12.10.8.олон улсын аялал жуулчлал, тэмцээн болон хуралд зориулсан бараа;

- 12.10.9.барааны сорьц, дээж, загвар;
- 12.10.10.үзэсгэлэнгийн бараа;
- 12.10.11.сурталчилгааны бараа.

13 дугаар зүйл. Ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга

13.1.Импортын барааны гаалийн үнийг нэг төрлийн барааны хэлцлийн үнийн аргаар тодорхойлох боломжгүй бол гаалийн үнийг нь тодорхойлж буй бараатай нэгэн зэрэг, эсхүл энэ хуулийн 3.1.8-д заасан хугацаанд импортолсон ижил төрлийн барааны хэлцлийн үнээр тодорхойлно.

13.2.“Ижил төрлийн бараа” гэдэгт үнийг нь тодорхойлж байгаа бараатай бүх талаараа адил биш боловч үндсэн шинж байдал, бүрдэл хэсэг, зориулалтаараа ижил, арилжааны талаас аль алиныгаа орлож чадах барааг ойлгоно.

13.3.Ижил төрлийн барааг тодорхойлоход барааны чанар, тэмдэг, нэр хүнд, гарал үүслийн улсыг харгалзан үзнэ.

13.4.Ижил төрлийн барааны хэлцлийн үнийн аргаар гаалийн үнийг тодорхойлохдоо худалдааны адил түвшинд байгаа, ойролцоо тоо хэмжээгээр импортолсон ижил төрлийн барааны хэлцлийн үнийг үндэслэнэ.

13.5.Ижил төрлийн бараа нь энэ хуулийн 13.4-т зааснаас өөр тоо хэмжээтэй, эсхүл худалдааны өөр нөхцөлд импортлогдсон байвал мэдүүлэгч нь зөрүүг харгалзан үнийн зохих өөрчлөлт хийж, үндэслэлийг баримтаар нотолно.

13.6.Ижил төрлийн импортын барааны хэлцлийн үнэ нь гаалийн байгууллагад хүлээн зөвшөөрөгдсөн үнэ байх бөгөөд уг үнэд барааг тээвэрлэх зай, ашиглах тээврийн хэрэгслийн төрлөөс хамаарах залруулга, тодотгол хийж болох бөгөөд тэдгээр нь үндэслэлтэй, үнэн зөв болохыг нотлох бичиг баримтаар баталгаажуулна.

13.7.Энэ хуулийн 13.6-д заасан хүлээн зөвшөөрөгдсөн үнэд залруулга, тодотгол хийх шаардлагатай боловч тэдгээрийг хийх боломжгүй, эсхүл залруулга, тодотголыг баталгаажуулах бичиг баримтгүй бол ижил төрлийн барааны хэлцлийн үнийн аргыг хэрэглэхийг хориглоно.

13.8.Ижил төрлийн барааны хэлцлийн үнийн аргаар гаалийн үнийг тодорхойлоход энэ хуулийн 11.3-т заасан зардлыг тооцно.

13.9.Ижил төрлийн барааны хэд хэдэн хэлцлийн үнийг үндэслэж болохоор байвал хамгийн бага үнийг нь сонгон авч гаалийн үнийг тодорхойлно.

13.10.Ижил төрлийн барааны хэлцлийн үнийн аргаар гаалийн үнийг тодорхойлохдоо энэ хуулийн 12.10-т заасан барааны үнийг хэрэглэхгүй.

14 дүгээр зүйл. Ялгаварт үнийн арга

14.1.Гаалийн үнийг энэ хуулийн 11, 12,13 дугаар зүйлд заасан гаалийн үнэлгээний аргаар тодорхойлох боломжгүй бол ялгаварт үнийн аргаар тодорхойлно.

14.2.Ялгаварт үнийн аргыг тухайн импортын барааг, эсхүл түүнтэй нэг төрлийн болон ижил төрлийн барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулж, өөрчлөлт оруулахгүйгээр дотоодын зах зээлд худалдааны анхны түвшинд худалдан борлуулсан тохиолдолд хэрэглэнэ

14.3.Импортын барааны гаалийн үнийг ялгаварт үнийн аргаар тодорхойлохдоо тухайн барааг, түүнтэй нэг төрлийн эсхүл ижил төрлийн барааг энэ хуулийн 3.1.8-д заасан хугацаанд харилцан хамааралгүй этгээдэд хамгийн их тоо хэмжээгээр худалдан борлуулсан нэгжийн үнийг суурь болгон авч санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримтыг үндэслэн дараах зардлыг хасна:

14.3.1.адил ангилал, бүлгийн барааг Монгол Улсад худалдан борлуулах үйл ажиллагаанд төлсөн, эсхүл төлбөл зохих зардал болон цэвэр ашиг (суутгал), комиссын зардал;

14.3.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан тээврийн болон даатгалын зардал;

14.3.3.Монгол Улсад төлсөн гаалийн болон бусад татвар.

14.4.Энэ хуулийн 14.3.1-д заасан "адил ангилал, бүлгийн бараа" гэдэгт тодорхой нэг үйлдвэрийн газар, түүний салбарын хүрээнд үйлдвэрлэгдсэн бүлэг бараа хамаарна.

14.5.Ялгаварт үнийн аргаар гаалийн үнийг нь тодорхойлох бараа өөр өөр үнээр, ижил тоо хэмжээгээр борлогдсон бол хамгийн бага үнийг суурь болгон сонгоно.

14.6.Хэрэв тухайн импортын бараа, эсхүл нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааг импортолсон шинж байдлаар нь худалдан борлуулсан тохиолдол байхгүй бол импортлогчийн хүсэлтээр тухайн импортын бараанд боловсруулалт хийсний дараа уг барааг харилцан хамааралгүй этгээдэд, хамгийн их тоо хэмжээгээр худалдан борлуулсан нэгж үнийг суурь болгон авч боловсруулалтаар нэмэгдсэн өртөг болон энэ хуулийн 14.3.1-14.3.3т заасан зардлыг хасч тооцно.

14.7.Боловсруулалтын явцад нэмэгдсэн өртгийг хасахдаа үйлдвэрлэлд хүлээн зөвшөөрөгдсөн томъёо, аргачлал, орц, нормын хэмжээ, үйлдвэрлэлийн бусад практикийг үндэслэнэ.

14.8.Боловсруулалтын явцад нэг төрлийн, эсхүл ижил төрлийн бараа нь өөрийн үндсэн шинж чанараа алдсан, эсхүл боловсруулалтын явцад бараа нь өөрийн үндсэн шинж чанараа алдаагүй боловч эцсийн бүтээгдэхүүний үнийн нөлөөлөл бага бол энэ хуулийн 14.6-д зааснаар гаалийн үнийг тодорхойлохыг хориглоно.

15 дугаар зүйл. Нийлбэр үнийн арга

15.1.Гаалийн үнийг энэ хуулийн 11, 12, 13, 14 дүгээр зүйлд заасан гаалийн үнэлгээний аргаар тодорхойлох боломжгүй бол нийлбэр үнийн аргаар тодорхойлно.

15.2.Нийлбэр үнийн аргаар гаалийн үнэ тодорхойлоход дараах үнэ, зардлыг нэмж тооцно:

15.2.1.тухайн барааг үйлдвэрлэхэд гарсан шууд зардал (материалын үнэ, хөдөлмөрийн хөлс гэх мэт) болон үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал;

15.2.2.үнийг нь тодорхойлж буй бараатай адил ангилал, бүлгийн барааны худалдаанд тусгагддаг бөгөөд тухайн барааг Монгол Улсад экспортлохтой холбоотойгоор үйлдвэрлэгчээс гарсан үйл ажиллагааны зардал болон цэвэр ашиг;

15.2.3.энэ хуулийн 11.3.1-11.3.5-д заасан зардал.

16 дугаар зүйл. Уялдуулан хэрэглэх үнийн арга

16.1.Энэ хуулийн 11-15 дугаар зүйлд заасан аргаар импортын барааны гаалийн үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд уялдуулан хэрэглэх үнийн аргаар барааны гаалийн үнийг тодорхойлох бөгөөд энэ нь гаалийн үнэлгээний сүүлчийн арга мөн.

16.2.Уялдуулан хэрэглэх үнийн аргыг дараах хоёр арга замаар хэрэгжүүлнэ:

16.2.1.гаалийн үнийг тодорхойлоход энэ хуулийн 11-15 дугаар зүйлд заасан аргуудын шаардлага, нөхцөлийг дараах байдлаар зөөлрүүлж хэрэглэх:

16.2.1.1.хэлцлийн үнийн аргыг хэрэглэх үед мэдүүлэгчийн гаргасан үнэ, зардлын бүрэлдэхүүн хэсэг нь бичиг баримтаар нотлогдоогүй тохиолдолд гаалийн байгууллага болон бусад импортлогч нарт байгаа адил төстэй баталгаатай мэдээллийг ашиглах, бусад зардалтай харьцуулах;

16.2.1.2.нэг төрлийн эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийн аргын үед харьцуулах хугацааг 6 сар, нэг жил, хоёр жилээр тооцох, эсхүл бараанд тавих шалгуур үзүүлэлтийн шаардлагыг багасгах;

16.2.1.3.ялгаварт үнийн аргын үед дотоодод борлуулсан хугацааны хязгаарыг ихэсгэж тооцох, суурь үнийн сонголтод тавигдах шаардлагыг багасгах, эсхүл дотоод зах зээлд борлогдсон нэг төрлийн эсхүл ижил төрлийн бараа байхгүй бол адил ангилал, бүлгийн барааг хамруулан авч үзэх;

16.2.1.4.нийлбэр үнийн аргын үед материалын үнэ болон өртгийг өөр ижил төстэй барааны үнэ, өртөгтэй адилтган авч үзэх, гаалийн хил хүртэл тээвэрлэсэн зардлыг бусад барааны зардалтай харьцуулах байдлаар тогтоох.

16.2.2.гаалийн үнийг тодорхойлоход олон улсын худалдааны практик болон тухайн үеийн арилжааны бусад мэдээлэлд тулгуурлах худалдааны дараах мэдээлэл, бичиг баримтыг ашиглах:

16.2.2.1.худалдагчийн үнийн жагсаалт, үнийн лавлагаа болон каталог;

16.2.2.2.статистикийн мэдээ, нийтээр хэрэглэж буй зардлын тариф;

16.2.2.3.экспортлогчийн үнийн санал, бараагаар төрөлжсөн олон улсын биржийн мэдээлэл, төрөлжсөн сонин хэвлэлийн мэдээлэл, зах зээлд зонхилох импортлогчдын гэрээ, түүний үнэ;

16.2.2.4.интернэтээр нийтэд зориулан тараасан экспортын үнэ;

16.2.2.5.хил залгаа улс орны Монгол Улсад экспортоор гаргаж байгаа барааны үнийн судалгаа;

16.2.2.6.хэлцлийн үнийн аргаар мэдүүлж, гаалийн байгууллага шалгаж зөвшөөрсөн энэ хуулийн 3.1.8-д заасан хугацаанд бүрдсэн үнийн дундаж үзүүлэлт.

16.3.Уялдуулан хэрэглэх аргаар гаалийн үнийг тодорхойлоход дараах үнийг үндэслэхийг хориглоно:

16.3.1.Монгол Улсад үйлдвэрлэсэн барааг дотоодын зах зээлд худалдан борлуулсан үнэ;

16.3.2.хоёр үнээс өндөр үнийг нь гаалийн зорилгоор сонгох систем;

16.3.3.хил орчмын худалдааны импортын барааны үнээс бусад экспортлогч орны дотоодын зах зээлийн үнэ;

- 16.3.4.нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны нийлбэр үнийг тодорхойлохоос бусад тохиолдолд гарсан үйлдвэрлэлийн зардал;
- 16.3.5.Монгол Улсаас өөр улсад экспортолсон барааны үнэ;
- 16.3.6.хийсвэр буюу зохиомол үнэ;
- 16.3.7.гаалийн доод үнэ.

16.4.Энэ хуулийн 16.2.2.2, 16.2.2.5, 16.2.2.6-д заасны дагуу тодорхойлсон үнийг гаалийн байгууллага Уялдуулсан системийн код, тодорхойлолтын хамт нийтэд зориулан сүлжээнд байршуулж, улирлаар тодотгол хийнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

ЭКСПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН ҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ

17 дугаар зүйл. Экспортын барааны гаалийн үнийг тодорхойлох арга

17.1.Экспортын барааны гаалийн үнэ нь Монгол Улсын хилийн өртөө хүртэл бараа нийлүүлэх нөхцөлөөр тодорхойлогдоно.

17.2.Экспортын барааны гаалийн үнийг тодорхойлоход дараах аргыг дор дурдсан дарааллын дагуу хэрэглэнэ:

- 17.2.1.хэлцлийн үнийн арга;
- 17.2.2.зардлаас тооцох үнийн арга;
- 17.2.3.нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга;
- 17.2.4.зах зээлийн мэдээлэл, судалгааны арга.

18 дугаар зүйл. Хэлцлийн үнийн арга

18.1.Хэлцлийн үнийн аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлоход хэлцлийн үнэд Монгол Улсын хил хүртэл уг барааг хүргэхэд барааны дараах зардал, төлбөр ороогүй бол нэмж тооцно:

- 18.1.1.тээврийн зардал;
- 18.1.2.тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой тээврийн болон экспортын бичиг баримт, бүрдүүлэлтийн хураамж, даатгалын шимтгэл, түүнчлэн барааг ачих, буулгах, хадгалах, шилжүүлэн ачихад гарсан зардал.

18.2.Дараах тохиолдолд экспортын барааны үнэлгээнд хэлцлийн үнийн аргыг хэрэглэхийг хориглоно:

- 18.2.1.хэлцэл нь гаалийн үнийг тодорхойлох боломжгүй нөхцөлөөр хийгдсэн бол;
- 18.2.2.худалдагч болон худалдан авагч нь харилцан хамаарал бүхий этгээдүүд бөгөөд энэ хамаарал нь хэлцлийн үнэд мэдэгдэхүйц нөлөөлсөн бол.

18.3.Харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн хэлцэл үнэд нөлөөлсөн гэдгийг энэ хуулийн 11.7.5-д заасны дагуу ойлгоно.

19 дүгээр зүйл. Зардлаас тооцох үнийн арга

19.1.Энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд зардлаас тооцох үнийн аргыг хэрэглэнэ.

19.2.Зардлаас тооцох үнийн аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо Монгол Улсын нутаг дэвсгэрт орших үйлдвэр, экспортлогч аж ахуйн нэгж, байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодит бичиг баримт, мэдээлэлд тулгуурлаж нэгж үнийг тодорхойлно.

19.3.Энэ хуулийн 19.1-д заасан аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо тухайн барааны нэгжид шууд болон шууд бус байдлаар шингэсэн дараах зардал, үнийг нэмж тооцно:

19.3.1.үнийг нь тодорхойлж буй барааг үйлдвэрлэхтэй холбогдсон дараах зардал:

19.3.1.1.үйлдвэрлэгчээс тухайн бараанд бүрэлдэхүүн хэсэг болгон хэрэглэсэн түүхий эд, үндсэн болон туслах материалын үнэ;

19.3.1.2.барааг үйлдвэрлэхтэй холбогдон гарах шууд болон шууд бус үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардал;

19.3.1.3.үйл ажиллагааны болон удирдлагын зардлын тухайн бараанд ногдох хэсэг;

19.3.1.4.цахилгаан, дулаан, уур ус, холбоо, түрээсийн зардлын тухайн бараанд ногдох хэсэг;

19.3.1.5.үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн элэгдлийн тухайн бараанд ногдох хэсэг;

19.3.1.6.тухайн бараанд ногдох татвар.

19.3.2.тухайн барааг Монгол Улсын хил хүртэл тээвэрлэх, ачих буулгах, хадгалах, шилжүүлэн ачих зардал, тэдгээртэй холбоотой даатгалын шимтгэл;

19.3.3.тухайн барааг үйлдвэрлэснээс болон экспортолсноос олсон ашиг.

19.4.Энэ хуулийн 19.3-т заасан зардал, үнэ, татвар, ашгийг давхардуулан тооцохгүй.

19.5.Энэ хуулийн 19.3-т заасан зардал, төлбөр, ашиг нь статистикийн болон татварын байгууллагад бүртгэгдсэн тухайн салбарын аж ахуйн нэгжийн дундаж үзүүлэлттэй ойролцоогүй, их зөрүүтэй бол зардлаас тооцох үнийн аргаар гаалийн үнийг тодорхойлохыг хориглоно.

20 дугаар зүйл. Нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга

20.1.Энэ хуулийн 18, 19 дүгээр зүйлд заасан аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлох боломжгүй бол нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийн аргыг хэрэглэнэ.

20.2. Экспортын барааны гаалийн үнийг нэг, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийн аргаар тодорхойлохдоо тухайн үед буюу энэ хуулийн 20.4.2-д заасан

хугацаанд гаалийн бүрдүүлэлт хийж Монгол Улсаас экспортолсон нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийг үндэслэнэ.

20.3.Нэг төрлийн, эсхүл ижил төрлийн бараа гэдгийг энэ хуулийн 12, 13 дугаар зүйлд заасан утгаар ойлгоно.

20.4.Нэг төрлийн, эсхүл ижил төрлийн барааны хэлцлийн үнийн аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо дараах үзүүлэлтийг харгалзан үзнэ:

20.4.1.харьцуулан жиших барааны үнэ нь тухайн, эсхүл өөр бусад аж ахуйн нэгж, байгууллагын хэлцлийн үнэ байх;

20.4.2.харьцуулан жиших бараа нь үнэлж байгаа бараатай нэгэн зэрэг, эсхүл 60-аас дээшгүй хоногийн дотор экспортлогдсон байх.

20.5.Энэ хуулийн 20.4.2-т заасан хугацаанд харьцуулан жиших хэд хэдэн хэлцлийн үнэ байвал олон тохиолдсон үнийг сонгоно.

21 дугаар зүйл. Зах зээлийн мэдээлэл, судалгааны үнийн арга

21.1.Экспортын барааны гаалийн үнийг тодорхойлох сүүлчийн арга нь зах зээлийн мэдээлэл, судалгааны үнийн арга болно.

21.2.Зах зээлийн мэдээлэл, судалгааны аргаар экспортын барааны гаалийн үнийг тодорхойлохдоо олон улсын худалдааны практик, тухайн үеийн дэлхийн зах зээлийн үнийн дараах мэдээлэл, судалгааг үндэслэнэ:

21.2.1.экспортлогчийн нийтэд зориулан тараасан үнийн жагсаалт, лавлагаа, интернэтийн мэдээлэл;

21.2.2.гадаад худалдааны болон гаалийн статистикийн мэдээ зэрэг олон нийтэд зориулсан мэдээ, мэдээлэл;

21.2.3.барааны төрөлжсөн биржийн мэдээлэл, төрөлжсөн сонин хэвлэлийн мэдээлэл, зах зээлд зонхилох экспортлогчдын гэрээ, түүний үнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

БАРААНЫ АНГИЛАЛ

22 дугаар зүйл. Гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт

22.1.Гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтыг дараах зорилгоор ашиглана:

22.1.1.гадаад худалдааны барааны гаалийн статистик мэдээлэл гаргах;

22.1.2.гаалийн тариф болон бусад албан татварын хувь хэмжээ тогтоох;

22.1.3.барааг тарифын бус хязгаарлалтад хамруулах;

22.1.4.гаалийн тарифын жагсаалт гаргах.

22.2.Гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.

22.3.Энэ хуулийн 22.2-т заасан нэмэлт, өөрчлөлтийг дараах үндэслэлээр оруулна:

22.3.1.Дэлхийн гаалийн байгууллагаас Уялдуулсан системийн Жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулсан;

22.3.2.олон улсын гэрээгээр гаалийн тариф, гарал үүслийг харилцан тохиролцсон;

22.3.3.үндэсний хууль тогтоомжоор гаалийн болон бусад албан татварын хувь хэмжээг тогтоох, барааг тарифын бус хязгаарлалтад хамруулсан.

21.4.Гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллага энэ хуулийн 4.3, 36.2 болон Гаалийн тухай хуулийн 42.1-д заасан жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулна.

23 дугаар зүйл. Барааг ангилах

23.1.Мэдүүлэгч нь гаалийн хилээр нэвтрүүлэх барааны ангиллын кодыг Гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтын дагуу тодорхойлж мэдүүлнэ

23.2.Гаалийн байгууллага мэдүүлэгчийн тодорхойлсон барааны ангиллын кодыг гаалийн мэдүүлэг болон барааг шалгах үед хянаж шийдвэрлэнэ.

23.3.Гаалийн байгууллага шийдвэр гаргахдаа Гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт, Тайлбар бичиг, Дэлхийн гаалийн байгууллагын Уялдуулсан системийн хорооноос гаргасан барааны ангиллын шийдвэрийг хэрэглэнэ.

23.4.Шаардлагатай тохиолдолд Гаалийн тухай хуулийн 139.1 дугаар зүйлд заасны дагуу магадлан шинжилгээнд хамруулж, шинжээчийн дүгнэлтийг харгалзан барааны ангиллын кодыг тодорхойлж шийдвэр гаргаж болно.

23.5.Барааны ангиллын талаар гаалийн байгууллагаас гаргасан шийдвэрийг мэдүүлэгч дагаж мөрдөх бөгөөд эс зөвшөөрвөл Гаалийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

23.6.Гомдлыг хянан шийдвэрлэх явцад энэ хуулийн 39.2-д заасны дагуу баталгаа гаргуулан мэдүүлэгчид барааг олгож болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

24 дүгээр зүйл. Барааны гарал үүсэл

24.1.Барааны гарал үүслийг эдийн засаг, худалдааны бодлого хэрэгжүүлэх зорилгоор энэ хууль болон олон улсын гэрээгээр тохирсон барааны гарал үүслийн дүрэмд заасны дагуу тодорхойлно.

24.2.Барааны гарал үүсэл нь улсуудын холбоо, гаалийн болон эдийн засгийн олон улсын холбоо, барааны гарал үүслийг тодорхойлох зорилгоор тусгайлан заасан нэг улсын тодорхой хэсэг, бүс нутаг байж болно.

24.3.Тарифын хөнгөлөлттэй нөхцөлөөр Монгол Улсаас экспортлох барааны гарал үүслийг мэдүүлэгчийн хүсэлтээр гаалийн байгууллага тодорхойлж, гарал үүслийн гэрчилгээ олгож болно.

24.4.Экспорт, импортын барааны гарал үүсэлтэй холбоотой харилцааг зохицуулах журмыг Засгийн газар батална.

25 дугаар зүйл. Импортын барааны гарал үүсэл

25.1. Импортын бараан гарал үүслийг хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй бус гэж ангилна.

25.2.Импортын бараанд гаалийн хөнгөлөлттэй тариф хэрэглэх үед хөнгөлөлттэй гарал үүслийн дүрмийг хэрэглэнэ. Хөнгөлөлттэй гарал үүслийн дүрмийг Олон улсын гэрээгээр тогтооно.

25.3.Импортын бараанд гаалийн нэн тааламжтай тариф хэрэглэх, демпингийн эсрэг, нөхөн тэгшитгэх, хамгаалалтын арга хэмжээг авах болон тарифын квот тогтоох үед хөнгөлөлттэй бус гарал үүслийг дүрмийг хэрэглэнэ. Хөнгөлөлттэй бус гарал үүслийн дүрмийг гаалийн хууль тогтоомжоор тогтооно.

26 дугаар зүйл. Барааг бүрэн үйлдвэрлэсэн улс

26.1.Барааг бүрэн үйлдвэрлэсэн улсыг тухайн импортын барааны гарал үүслийн улс гэж үзнэ.

26.2.Дараах нөхцөлийг хангасан тохиолдолд барааг тухайн улсад бүрэн үйлдвэрлэсэн гэж үзнэ:

26.2.1.тухайн улсын газрын гадаргуу, түүний хэвлий, нутаг дэвсгэрийн ус, түүний ёроолоос олборлосон эрдэс бүтээгдэхүүн;

26.2.2.тухайн улсад хураан авсан хүнсний ногоо;

26.2.3.тухайн улсад төрсөн, бойжсон амьд амьтан;

26.2.4.тухайн улсын мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн;

26.2.5.тухайн улсын нутаг дэвсгэрт агнасан ан, загас агнуурын бүтээгдэхүүн;

26.2.6.тэнгисийн загас агнуурын бүтээгдэхүүн, тухайн улсын хөлөг онгоцоор тэнгисийн уснаас гаргаж авсан бусад бүтээгдэхүүн;

26.2.7.энэ хуулийн 26.2.6-д заасан бүтээгдэхүүнээр тухайн орны хөлөг онгоцон дээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн;

26.2.8.тухайн улсын нутаг дэвсгэрийн усанд үл хамаарах далай, тэнгисийн ёроолоос олборлосон эрдэс бүтээгдэхүүн;

26.2.9.тухайн улсад гагцхүү түүхий эдийн зориулалтаар цуглуулсан хуучин эд зүйлс, үйлдвэрийн хог, хаягдал;

26.2.10.энэ хуулийн 26.2.1-26.2.9-д заасан бүтээгдэхүүнээр тухайн улсад үйлдвэрлэсэн бараа.

27 дугаар зүйл. Бараанд үлэмж хэмжээний боловсруулалт хийх

27.1.Барааг үйлдвэрлэхэд хоёр, түүнээс дээш улс орон оролцсон тохиолдолд барааны гарал үүслийн улсыг түүнд үлэмж хэмжээний боловсруулалт хийсэн улсаар тодорхойлно.

27.2.Бараанд үлэмж хэмжээний боловсруулалт хийгдсэн болохыг дараах шалгуураар тогтооно:

27.2.1.барааг боловсруулах, үйлдвэрлэх үйл ажиллагааны улмаас барааны ангиллын код нь Уялдуулсан системийн зүйлийн түвшинд өөрчлөгдсөн байвал;

29.2.2.барааны үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаа нь тухайн улсыг барааны гарал үүслийн улсаар тооцоход хангалттай бол;

27.2.3.тухайн бараанд ашигласан материалын эсхүл нэмэгдсэн өртөг нь эцсийн бүтээгдэхүүний өртгийн 50 болон түүнээс дээш хувийг эзэлж байвал.

27.3.Бараанд үлэмж хэмжээний боловсруулалт хийгдсэн шалгуурт дараах үйл ажиллагаа хамаарахгүй:

27.3.1.барааг хадгалах, тээвэрлэх явцад түүний бүрэн бүтэн байдлыг хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа;

27.3.2.барааг худалдах, тээвэрлэхэд бэлтгэх үйл ажиллагаа;

27.3.3.энгийн угсрах үйл ажиллагаа;

27.3.4.өөр өөр улсаас гарал үүсэлтэй барааг хооронд нь холих үйл ажиллагаа.

27.4.Энэ хуулийн 27.3.4-т заасан тохиолдолд эцсийн бүтээгдэхүүний шинж чанар нь хольж байгаа бараа бүрийн шинж чанартай адил байна.

28 дугаар зүйл. Барааны гарал үүслийн улсыг тодорхойлох онцлог тохиолдол

28.1.Үйлдвэрлэл, тээвэрлэлтийн нөхцөлийн улмаас нэг ачилтаар илгээх боломжгүйгээс хэд хэдэн ачилтаар илгээгдсэн, эсхүл угсраагүй буюу задалж салгасан бараа, түүнчлэн тээвэрлэлтийн алдаанаас хэд хэдэн ачилтаар салангид ирсэн барааг гарал үүслийн хувьд нэг бараа гэж үзнэ.

28.2.Дараах нөхцөлийг хангасан бол барааг гарал үүслийн хувьд нэг бараа гэж тооцно:

28.2.1.барааг угсраагүй, эсхүл задалж салган хэд хэдэн ачилтаар илгээх болсон шалтгааныг зааж, барааны ангиллын код, үнэ, гарал үүслийн улсыг ачилт тус бүрээр заасан жагсаалтыг гарган гаалийн байгууллагад урьдчилан мэдэгдсэн байх, эсхүл алдааны улмаас барааг салгаж тээвэрлэснийг батлах бичиг баримтыг гаргаж өгсөн байх;

28.2.2.ачилт бүрт хамрагдах барааг нэг улсаас, нэг илгээгчээс нийлүүлсэн байх;

28.2.3.ачилт бүрт хамрагдах барааг гаалийн нэг байгууллагад мэдүүлсэн байх;

28.2.4.ачилт бүрт хамрагдах барааг гаалийн байгууллага гаалийн мэдүүлгийг хүлээн авснаас хойш 3 сарын дотор гаалийн нутаг дэвсгэрт оруулсан байх.

28.3.Мэдүүлэгчийн хүсэлтээр энэ хуулийн 28.2.4.-т заасан хугацааг нэг хүртэл сараар 1 удаа сунгаж болно.

28.4.Машин, тоног төхөөрөмж, аппарат, тээврийн хэрэгслийг тэдгээрийг ашиглахад шаардагдах сэлбэг, эд анги, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хамт нийлүүлсэн тохиолдолд тэдгээрийн гарал үүслийн улс нь ижил байна.

28.5.Гаалийн нутаг дэвсгэрт оруулж байгаа барааны сав, баглаа боодол нь түүнийг тусад нь мэдүүлснээс бусад тохиолдолд тухайн бараатай ижил гарал үүсэлтэй байна.

28.6.Барааны гарал үүслийг тодорхойлоход түүний үйлдвэрлэл, боловсруулалтад ашигласан цахилгаан эрчим хүч, машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн гарал үүслийн улсыг тооцохгүй.

29 дүгээр зүйл.Барааны гарал үүслийн улсыг нотлох баримт бичиг

29.1.Барааны гаалийн нэн тааламжтай болон хөнгөлөлттэй тарифт хамрагдахын тулд мэдүүлэгч нь барааны гарал үүслийг нотлох бичиг баримтыг гаалийн байгууллагад гаргаж өгнө.

29.2.Гаалийн байгууллага нь барааны гарал үүслийн улсыг нотлох баримтыг нягтлан шалгаж болно.

29.3.Импортын барааны гарал үүслийн улсыг нягтлан шалгах хугацаа 30 хоногоос хэтрэхээргүй байх бөгөөд гаалийн удирдах төв байгууллага уг хугацааг нэг удаа 30 хоногоор сунгаж болно.

29.4.Барааны гарал үүслийг нотлох баримт бичиг нь дараах хэлбэртэй байна:

29.4.1. барааны гарал үүслийн мэдүүлэг буюу үйлдвэрлэгч, худалдагч, экспортлогчоос барааны гарал үүслийн талаар тусгасан мэдээлэл бүхий гадаад худалдааны болон тээврийн бичиг баримт;

29.4.2.барааны гарал үүслийг баталгаажуулсан мэдүүлэг буюу тухайн улсын эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан гарал үүслийн мэдүүлэг;

29.4.3.барааны гарал үүслийн гэрчилгээ буюу барааны гарал үүслийг гэрчилж, тухайн улсын эрх бүхий байгууллагаас тусгай маягтаар баталгаажуулан олгосон гэрчилгээ.

29.5.Барааны гарал үүслийг нотлох бичиг баримтыг дараах бараанд шаардахгүй:

29.5.1.гаалийн нийт үнийн дүн, тоо хэмжээ нь хууль тогтоомжид заасны дагуу гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх хэмжээнээс хэтрээгүй зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлс болон улс хоорондын шуудан илгээмжийн бараа;

29.5.2.гаалийн үнийн нийт дүн нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс хэтрээгүй, арилжааны шинж чанартай бараа;

29.5.3.хоёр талт буюу олон талт хэлэлцээрийн дагуу гарал үүслийн нотлох бичиг баримт гаргаж өгөх шаардлагагүй бараа.

НАЙМДУГААР БҮЛЭГ

УРЬДЧИЛСАН ШИЙДВЭР

30 дугаар зүйл. Урьдчилсан шийдвэр.

30.1. Гаалийн байгууллага дараах урьдчилсан шийдвэр гаргана:

30.1.1. барааны ангиллын;

30.1.2. гарал үүслийн.

30.2. Гаалийн байгууллага урьдчилсан шийдвэрийг, шинэчлэх, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, урьдчилсан шийдвэр гаргахаас татгалзах эрхтэй.

30.3. Барааны ангилал, гарал үүслийн урьдчилсан шийдвэр гаргах журмыг гаалийн удирдах төв байгууллагын дарга батална.

30.4. Гаалийн байгууллага мэдүүлэгчийн хүсэлтээр гаалийн үнэ, үнэлгээ болон татварын чөлөөлөлтийн асуудлаар урьдчилсан шийдвэр гаргаж болно.

31 дүгээр зүйл. Урьдчилсан шийдвэр гаргуулах тухай хүсэлт.

31.1. Хүсэлт гаргагч урьдчилсан шийдвэр гаргуулах хүсэлтийг гаалийн байгууллагад бичгээр гаргана.

31.2. Хүсэлт гаргагч нь зөвхөн Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд, иргэн байна.

31.3. Урьдчилсан шийдвэр гаргуулах хүсэлтийг бараа улсын хилээр оруулах эсхүл гаргахаас дор хаяж 90 хоногийн өмнө гаалийн байгууллагад гаргаж өгнө.

31.4. Хүсэлт гаргагч нь барааны ангилал, гарал үүслийн урьдчилсан шийдвэр гаргуулах хүсэлтэд барааны загвар, дээж, тодорхойлолт, гэрэл зураг, бүдүүвч зураг, худалдааны болон техникийн бичиг баримтыг хавсаргана.

31.5. Хүсэлт гаргагч гаргаж өгсөн бичиг баримт хангалтгүй тохиолдолд гаалийн байгууллага тэдгээрийг хүлээн авснаас хойш 14 дотор нэмэлт материал, мэдээлэл ирүүлэх тухай хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.

31.6. Хүсэлт гаргагч нэмэлт материал, мэдээлэл гаргах тохиолдолд гаалийн байгууллагад 30 хоногийн дотор өгнө.

32 дугаар зүйл. Урьдчилсан шийдвэр гаргах, шинэчлэх, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, урьдчилсан шийдвэр гаргахаас татгалзах

32.1. Гаалийн байгууллага урьдчилсан шийдвэр гаргуулах хүсэлтийг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор шийдвэрлэнэ.

32.2. Урьдчилсан шийдвэр нь зөвхөн тухайн хүсэлт гаргагч этгээдэд хамаарна.

32.3.Урьдчилсан шийдвэр нь шийдвэр гарснаас хойш гурван жилийн хугацаанд хүчинтэй байна.

32.4.Гаалийн байгууллага дараах тохиолдолд урьдчилсан шийдвэрийг цуцалж, шинэчлэн гаргана:

32.4.1.Дэлхийн гаалийн байгууллагын уялдуулсан системийн хорооноос гаргасан барааны ангиллын шийдвэрт, эсхүл гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт орсон;

32.4.2.Монгол Улсын олон улсын гэрээгээр тохирсон гарал үүслийн дүрэм, тусгай шалгуурт өөрчлөлт орсон;

32.4.3.үндэсний хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон;

32.5.Гаалийн байгууллага эсхүл хүсэлт гаргагч урьдчилсан шийдвэр гаргах үед алдаа гарсныг илрүүлсэн бөгөөд энэ нь барааны ангиллын кодоод нөлөөлөхөөргүй бол гаалийн байгууллага урьдчилсан шийдвэрт өөрчлөлт оруулна.

Гаалийн байгууллага урьдчилсан шийдвэрийг хуурамч бичиг баримт, мэдээлэлд үндэслэн, эсхүл гаалийн байгууллагад гаргаж өгсөн мэдээлэл гаалийн хяналт шалгалтаар зөрүүтэй болох нь нотлогдсон бол уг шийдвэрийг хүчингүй болгоно.

32.7.Урьдчилсан шийдвэрийг дараах тохиолдолд гаргахаас татгалзана:

32.7.1.урьдчилсан шийдвэр гаргуулах хүсэлт, түүнд хавсаргасан бичиг баримт болон гаалийн байгууллагаас шаардсан нэмэлт мэдээлэл нь хоорондоо зөрчилдсөн;

32.7.2.хүсэлт гаргагч нэмэлт мэдээллийг гаалийн байгууллагаас тогтоосон хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл дутуу материал бүрдүүлж өгсөн;

32.7.3.уг бараатай холбоотой асуудлаар шүүхийн шийдвэр гарсан, эсхүл шийдэгдэхээр хүлээгдэж байгаа.

32.8.гаалийн байгууллага урьдчилсан шийдвэр гаргахаас татгалзсан, шийдвэрээ өөрчилсөн, эсхүл хүчингүй болгосон, буцаан татсан бол энэ тухайгаа хүсэлт гаргагчид бичгээр болон цахимаар ажлын 3 хоногт багтаан мэдэгдэнэ.

32.9.Хэрэв хүсэлт гаргагч зөвшөөрсөн бол гаалийн байгууллага урьдчилсан шийдвэрийг бүрэн, эсхүл хэсэгчлэн нийтэд мэдээлж болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАР НОГДУУЛАХ, ХУРААХ, ТӨЛӨХ

33 дугаар зүйл. Гаалийн болон бусад татвар ногдуулах

33.1.Гаалийн нутаг дэвсгэрт оруулах, эсхүл түүнээс гаргах бараанд гаалийн болон бусад татвар ногдуулах бөгөөд энэ заалт нь гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх бараанд нэгэн адил хамаарна

33.2.Гаалийн болон бусад татвар ногдуулах суурь нь барааны гаалийн үнэ, түүний тоо хэмжээ байна.

33.3.Гаалийн болон бусад татварыг Гаалийн тухайн хуулийн 71.8-д зааснаар мэдүүлсэнд тооцох өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа гаалийн тариф болон бусад татварын хувь хэмжээ, валютын ханшаар тооцож төгрөгөөр ногдуулна.

33.4.Гаалийн тухай хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу урьдчилан мэдүүлсэн тохиолдолд барааг гаалийн хяналтаас гаргахыг зөвшөөрөх өдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа гаалийн тариф болон бусад татварын хувь хэмжээ, валютын ханшаар тооцож төгрөгөөр ногдуулна.

33.5.Гаалийн тухай хуулийн 202, 210 дугаар зүйлд заасан барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах бол ийнхүү оруулах өдрийн гаалийн тариф болон бусад татварын хувь хэмжээ, валютын ханшийг баримтална.

33.6.Гаалийн болон бусад татварыг төгрөгөөр илэрхийлэхэд Монголбанкнаас зарласан чөлөөтэй хөрвөдөг гадаад валютын тухайн өдрийн албан ханшийг баримтална.

33.7.энэ хуулийн 33.6-д зааснаас бусад албан ёсоор зарладаггүй гадаад валютын төгрөгтэй харьцах ханшийг Монголбанк тухай бүр гаргаж өгнө.

33.8.Гаалийн хууль тогтоомж зөрчиж нэвтрүүлсэн бараанд гаалийн болон бусад татварыг ногдуулахдаа Монгол улсын хил нэвтрүүлсэн өдөр, хэрэв энэ өдрийг тогтоох боломжгүй бол зөрчил илрүүлсэн өдөр хүчин төгөлдөр мөрдөж байгаа тариф, валютын ханшийг мөрдөнө.

33.9.Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан тогтворжуулах гэрчилгээтэй бол уг гэрчилгээнд заасан хувь, хэмжээгээр гаалийн болон бусад татварыг төлнө.

34 дүгээр зүйл. Гаалийн болон бусад татварыг хураах

34.1.Гаалийн байгууллага татвар төлөгчөөс гаалийн болон бусад татвар, хураамжийг хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ.

34.2.Дараах тохиолдолд гаалийн болон бусад татварын баталгаа болох мөнгөн хөрөнгийг төрийн сангийн тусгай дансанд байршуулна:

34.2.1 энэ хуулийн 4.7-д заасан гарал үүслийн нотлох бичиг баримтыг нөхөн гаргах;

34.2.2.энэ хуулийн 6.1-д заасан хамгаалалтын (safeguard), демпингийн эсрэг (antidumping), эсхүл хариу арга хэмжээ(countervailing)-ний татварыг түр хугацаагаар ногдуулах;

34.2.3.энэ хуулийн 9.6, 9.7-д заасны дагуу мэдүүлэгч гаалийн үнэлгээний асуудлаар гомдол гаргах;

34.2.4 энэ хуулийн 23.5-д заасны дагуу мэдүүлэгч барааны ангиллын асуудлаар гомдол гаргах;

34.2.5. Гаалийн тухай хуулийн 202, 210 дугаар зүйлд заасан барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах.

34.3. Төрийн сангийн тусгай дансанд байршуулах баталгааны мөнгөн хөрөнгийн хэмжээг энэ хуулийн 39.3-т зааснаар тооцсон байна.

35 дугаар зүйл. Гаалийн болон бусад татвар үл ногдуулах

35.1.Дараах бараанд гаалийн болон бусад татвар үл ногдуулна:

35.1.1.хилийн чанадаас тусгай горимд шууд оруулах болон тэндээс хилийн чанадад шууд гаргах бараа;

35.1.2.ташаарч тээвэрлэгдсэний улмаас буцааж тээвэрлэх бараа;

35.1.3.гаалийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэх бараа;

35.1.4.шилжүүлэн ачих горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийх бараа;

35.1.5.устгах горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийх бараа.

35.1.6 Гаалийн тухай хуулийн 102.1,103.1, 112.2 117.5, 117.7, 225.1, 250.1, 270.1-д заасан бараа, тээврийн хэрэгсэл;

35.1.7.тухайн жилд нэг хүлээн авагчийн нэр дээр ирсэн барааны гаалийн үнийн дүн нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээшгүй байх хил дамнасан цахим худалдаагаар худалдан авсан бараа, загвар дээж.

36 дугаар зүйл. Гаалийн татвараас чөлөөлөгдөх бараа

36.1.Гаалийн нутаг дэвсгэрт оруулах дараах барааг гаалийн татвараас чөлөөлнө:

36.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмж тэдгээрийн эд анги, хиймэл эд, эрхтэн;

36.1.2.хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн бараа;

36.1.3.гадаад валют болон гадаадад захиалгаар хийлгэсэн Монгол Улсын мөнгөн тэмдэгт;

36.1.4.эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, цусан бүтээгдэхүүн, донорын эд, эрхтэн;

36.1.5.хийн түлш, түүний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоноглол.

36.1.6.импортоор оруулах бөөрөнхий мод, гуалин, зүсмэл материал, хориглосноос бусад мод, сөөгний үр, тарьц, суулгац;

36.1.7.иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг;

36.1.8.зөвхөн тахир дутуу тэргэнцэртэй хүнийг суулгах, буулгах зам, тавцан, өргүүртэй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө жолоодох, удирдлага нь зөвхөн гар ажиллагаатай, дээрхийн адил бүрэн тоноглогдон үйлдвэрлэгдсэн, тусгай зориулалтын автомашиныг нэг хүнд нэг удаа;

36.1.9.инновацийн төслөөр дотоод, гадаадын зах зээлд шинэ бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай, дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодис.

36.1.10.тухайн жилд нэг хүний нэр дээр хүлээн авсан, барааны гаалийн үнийн дүн нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлснээс дээшгүй, арилжааны шинж чанаргүй улс хоорондын шуудан илгээмж болон хил дамнасан цахим худалдаанаас хувийн хэрэглээндээ худалдаж авсан бараа.

36.1.11.гэрээлэгч болон туслан гүйцэтгэгч нь газрын тос, уламжлалт бус газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан хайгуулын нийт хугацаанд болон ашиглалтын эхний таван жилийн хугацаанд импортлолсон тусгай зориулалтын машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоноглол, түүхий эд, материал, тайлан материал, дээж болон газрын тос.химийн болон тэсрэх бодис, сэлбэг хэрэгсэл;

36.1.12.сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг.

36.1.13.спортын зориулалтын тоног төхөөрөмж, хэрэглэл.

36.1.14.чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулах зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй бараа.

36.1.15.олон улсын гэрээнд татвараас чөлөөлөгдөхөөр заасан бараа;

36.2.Энэ хуулийн 36.1.5, 36.1.6, 36.1.7, 36.1.9, 36.1.12, 36.1.13, 36.1.14-д хамаарах барааны жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар батална.

36.3.Гаалийн татвараас чөлөөлөх харилцааг гагцхүү энэ хуулиар зохицуулна.

37 дугаар зүйл. Гаалийн болон бусад татвар төлөх

37.1.Гаалийн болон бусад татвар, хураамжийг татвар төлөгч төлнө. Гаалийн болон бусад татварыг нэн даруй төлөх бөгөөд энэ хугацаа нь ногдуулалт хийснээс хойш ажлын 10 хоногоос хэтрэхгүй байна.

37.2 .Татвар төлөгч нь гаалийн болон бусад татвар, хураамжийг цахим төлбөр, тооцооны хэлбэр ашиглан төлж болно.

37.3.Гаалийн байгууллага дараах тохиолдолд гаалийн болон бусад албан татварыг нөхөн төлүүлнэ:

37.3.1.гаалийн болон бусад албан татвараас чөлөөлж гаалийн нутаг дэвсгэрт оруулсан бараа алдагдсан, дутсан, өөр зориулалтаар ашигласан, бусдад шилжүүлсэн;

37.3.2. гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг буцаан гаргаагүй, эсхүл энэ горимд байршуулсан бараа алдагдсан, гаалийн байгууллагын зөвшөөрөлгүй устгасан;

37.3.3.гаалийн бүрдүүлэлтийн тусгай горимд байршуулсан бараа алдагдсан, дутсан, гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйг устгасан;

37.3.4.гаалийн байгууллагын дотоод хяналт болон бусад шалгалтаар алдаа, зөрчил илэрсэн.

37.4.Татвар төлөгч нь гаалийн болон бусад татвар, хураамж төлөх зорилгоор гаалийн байгууллагын дансанд урьдчилгаа төлбөр хийж болно.

37.5.Гаалийн байгууллагын дансанд байршуулсан урьдчилгаа төлбөр, төрийн сангийн тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгөд хүү тооцохгүй.

37.6.Гаалийн мэдүүлэг нь дараах тохиолдолд санхүүгийн хувьд хүчин төгөлдөр анхан шатны баримт болно:

37.6.1.гаалийн болон бусад татвар, хураамжийг төлсөн, эсхүл

37.6.2. Засгийн газраас энэ хуулийн 38.1-д заасны дагуу гаалийн болон бусад татвар төлөх хугацааг сунгах, эсхүл хэсэгчлэн төлүүлэх шийдвэр гарсан, эсхүл

37.6.3.гаалийн байгууллагаас энэ хуулийн 39.2-т заасан аль нэг хэлбэрээр гаалийн болон бусад татвар төлөх баталгаа гаргуулсан.

37.7.Дараах тохиолдолд гаалийн болон бусад татвар төлсөнд тооцно:

37.7.1.ногдуулсан татвар, хураамжийн мөнгөн дүнг банкнаас гаалийн байгууллагын, эсхүл төрийн сангийн дансанд шилжүүлсэн;

37.7.2.гаалийн байгууллагын дансанд хийсэн урьдчилгаа төлбөрөөс ногдуулсан татварын хэмжээгээр суутгал хийсэн;

37.8.Гаалийн байгууллага нь гаалийн болон бусад татвар, хураамж төлснийг нотлох баримт болох гаалийн хүчин төгөлдөр мэдүүлгийн хувийг татвар төлөгчид олгож болно.

38 дугаар зүйл. Гаалийн болон бусад татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлөх.

38.1.Гаалийн болон бусад татварыг төлөх хугацааг 2 сар хүртэл хугацаагаар сунгах, эсхүл 2 сарын хугацаанд хэсэгчлэн төлөх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.

38.2.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2.1-11.2.3-т заасан салбарын улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчийн тухайн төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирж байгаа техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдлийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 2 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болно.

38.3.Энэ хуулийн 38.2-т заасан улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээнд хийх хөрөнгө оруулалтын хэмжээг Засгийн газар тогтооно.

38.4.Гаалийн итгэмжлэгдсэн операторын хувьд гаалийн болон бусад татвар төлөх хугацааг 1 сар хүртэл хугацаагаар сунгах, эсхүл хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг гаалийн удирдах төв байгууллага гаргаж болно.

39 дүгээр зүйл. Гаалийн болон бусад татвар төлөх баталгаа

39.1.Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхэд гаалийн байгууллага нь гаалийн болон бусад татвар төлөх баталгааг гаргуулж болно.

39.2.Мэдүүлэгч гаалийн болон бусад татвар төлөх баталгааг дараах хэлбэрээр гаргаж болно:

- 39.2.1.гаалийн хилээр нэвтрүүлж буй бараа барьцаалах;
- 39.2.2.мөнгөн хөрөнгө төрийн сангийн тусгай дансанд байршуулах;
- 39.2.3.банкны баталгаа гаргах;
- 39.2.4.олон улсын гэрээнд заасан бусад хэлбэр.

39.3.Гаалийн болон бусад татвар төлөх баталгаа нь ердийн тарифаар ногдуулсан гаалийн болон бусад татварын дүн дээр түүний 10 хувийг нэмсэн хэмжээнээс хэтрэхээргүй байна.

39.4.Гаалийн болон бусад татвар төлөх баталгаа гаргах журмыг Засгийн газар батална.

40 дүгээр зүйл. Гаалийн болон бусад татварыг хорогдуулж тооцох

40.1.Мэдүүлэгчид бараа олгохоос өмнө гаалийн хяналтад байх хугацаанд тоо хэмжээ нь дутсан, жин нь багассан, гэмтсэн, чанараа алдсан, элэгдсэн, зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь холбогдох бичиг баримт, гаалийн хяналт шалгалтаар нотлогдсон тохиолдолд гаалийн байгууллага түүнд ногдуулах гаалийн болон бусад татварыг хорогдуулан тооцож болно.

41 дугаар зүйл. Гаалийн болон бусад татвар төлөх баталгаа болон илүү төлөгдсөн татварыг буцаан олгох

41.1. Гаалийн байгууллага нь гаалийн болон бусад татвар төлөх баталгааг дараах тохиолдолд буцаан олгоно:

41.1.1.гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг хугацаанд нь буцаан гаргасан;

41.1.2.гаалийн нутаг дэвсгэрээс түр хугацаагаар гаргасан барааг хугацаанд нь буцаан оруулсан;

41.1.3.гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан бараа татварын чөлөөлөлтөд хамрагдсан эсхүл татваргүй горимд шилжсэн.

41.2.Гаалийн байгууллага илүү төлөгдсөн гаалийн болон бусад татварыг дараах тохиолдолд буцаан олгоно:

41.2.1.бараа ердийн тарифаас нэн тааламжтай, эсхүл хөнгөлөлттэй тарифт, нэн тааламжтай тарифаас хөнгөлөлттэй тарифт шилжсэн;

41.2.2.энэ хуулийн 6.1-д заасны дагуу хамгаалалтын (safeguard), демпингийн эсрэг (antidumping), эсхүл хариу арга хэмжээний (countervailing) талаар гарсан шийдвэр;

41.2.3.энэ хуулийн 9.6, 9.7-д заасны дагуу гаалийн байгууллагын тодорхойлсон үнээс татгалзсан;

41.2.4.энэ хуулийн 23.5-д заасны дагуу барааны ангиллын шийдвэр гарсан;

41.2.5.гаалийн болон бусад татварыг илүү төлсөн, эсхүл илүү ногдуулсан бусад тохиолдолд.

41.3.Буцаан олгох гаалийн болон бусад татварт гаалийн байгууллага хүү төлөхгүй.

41.4.Мэдүүлэгч хүсвэл илүү төлөгдсөн татварыг дараагийн ачилтаар ирэх барааны татварт шилжүүлэн тооцож болно.

41.5.Энэ хуулийн 41.1, 41.2-т заасан нөхцөл хангагдсан боловч гаалийн байгууллагын дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцаан авах хүсэлтээ гаалийн байгууллагад ирүүлээгүй бол улсын төсөвт шилжүүлж хаана.

41.6.Гаалийн болон бусад албан татварын чөлөөлөлт эдлүүлэх, хорогдуулан тооцох, буцаан олгох үйл ажиллагааны журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

42 дугаар зүйл. Гаалийн болон бусад татвар, хураамж төлөх үүрэг дуусгавар болох

42.1.Гаалийн болон бусад татвар төлөх татвар төлөгчийн үүрэг дараах тохиолдолд дуусгавар болно:

42.1.1.татвар, хураамж төлсөн;

42.1.3.гаалийн болон бусад татвар төлөх баталгаа гаргасан банк уг татварыг төлсөн;

42.1.4.гаалийн болон бусад татварыг барьцааны гэрээний хугацаанд төлсөн;

42.1.5.гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан, эсхүл түүнээс түр хугацаагаар гаргасан барааг хугацаанд нь буцаан гаргасан, эсхүл буцаан оруулсан;

42.1.6.барааг гаалийн байгууллага хураасан;

42.1.7.гаалийн болон бусад татварыг төлүүлсэн;

42.1.8.тухайн төрлийн татварын өрийг төлсөн;

42.1.9.энэ хуулийн 41.4-т заасны дагуу татварыг шилжүүлэн тооцсон.

43 дугаар зүйл. Банкны үүрэг

43.1.Энэ хуулийн 39.2.2–т заасны дагуу мэдүүлэгчийн өмнөөс гаалийн болон бусад татвар төлөх баталгаа гаргасан бөгөөд мэдүүлэгч нь уг баталгаанд заасан хугацаанд тэдгээрийг төлөөгүй бол банк татварыг гаалийн байгууллагад төлөх үүрэгтэй.

43.2 Банк энэ хуулийн 43.1, 43.3-т заасан үүргийг биелүүлээгүй бол төлөгдөөгүй татварын дүнд алданги тооцно.

43.3.Банк гаалийн болон бусад татвар, хураамжийг 12 цагийн дотор гүйлгээ хийж тухайн өдөрт багтаан төрийн сангийн дансанд шилжүүлнэ.

43.4.Гаалийн хяналт шалгалтад шаардагдах гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гаалийн байгууллагад гаргаж өгнө.

44 дүгээр зүйл. Гаалийн болон бусад төлөөгүй татварын өр хураах

44.1.Энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан хугацаанд, эсхүл мөн хуулийн 39 дүгээр зүйлд заасан баталгааны дагуу гаалийн болон бусад татвар, хураамж төлөөгүй бол тэдгээрийг хураах ажиллагааг Татварын ерөнхий хуулийн дагуу хэрэгжүүлнэ.

44.2.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 44.1-д заасан өр хураах үйл ажиллагааг гаалийн байгууллагад ажиллаж буй гаалийн улсын байцаагчийн эрх бүхий этгээд хэрэгжүүлж болно.

44.3.Төлөөгүй татвар, хураамжид ногдох алдангийн хэмжээг Татварын ерөнхий хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу тооцож хураана.

АРАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

45 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

45.1.Энэ хуулийг оны ... дугаар сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА